

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ОЛОН НИЙТ



Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эрүүл байх эрхтэй. Эрүүл байх гэдэг нь илчлэг сайтай хүнс хэрэглэх, байнгын дасгал хөдөлгөөн хийх, өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролтой болох, өвчин тусвал саадгүй эмчлүүлдэг байх хэрэгтэй. Ялангуяа тэдний нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд онцгойлон анхаарах хэрэгтэй. Мөн хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүд авъяас чадвараа хөгжүүлж, мэдлэг мэргэжилтэй болж нийгэмд өөрийн гэсэн байр суурийг эзлэх боломжоор хангагдах ёстой.



БҮЛЭГ 1: Хөгжлийн бэрхшээл ба олон нийт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд бие даасан үйл ажиллагаа нь хязгаарлалтанд орсон үед “эрүүл мэндийн байдал сулрах” гэсэн нэр томъёог ашигладаг. Тэр хязгаарлалт гэдэгт хараагүй болох, сонсголгүй болох, ярих, алхахад бэрхшээлтэй болох, аливааг сурах ойлгоход хүндрэлтэй болох, мөн саажилттай болох зэргийг багтааж ойлгодог.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хөдлөх, харах, сонсох, сурах, аливааг ойлгох нь жирийн эмэгтэйчүүдийнхээс ялгаатай байж болно. Бусадтай харьцах, хоол идэх, усанд орох, хувцаслах, унтаж амрах, хүүхдээ асрах, хооллох нь бусдаас өөр байж болно. Гэхдээ аливааг өөрийн хязгаарлагдмал байдалдаа тохируулан хийх нь тэдний амьдралын нэг хэсэг.



Хөгжлийн бэрхшээлтэй байдлаас шалтгаалсан хүндрэлүүдийг шийдвэрлэх аргыг оллоо гэхэд тухайн эмэгтэй эрүүл мэндийн тусламж авах, боловсролтой болох, мэргэжлийн сургалтад хамрагдах, ажилд ороход нь нийгэм, бие бялдар, соёл, эдийн засгийн олон бэрхшээлүүдтэй тулгардаг.

Саад бэрхшээлийг бий болгодог хандлагууд

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд юуг хийж чадах, юуг чадахгүй талаарх ташаа ойлголт хандлагууд нь тэднийг эрүүл урт удаан амьдрах, нийгэмд өөрийн байр суурийг эзлэхэд саад болдог. Тэдний хөгжлийн бэрхшээлтэй байдлаас нь үүсэлтэй саадууд боловсролтой болох, ажил хийх, нийгэмтэй харьцахад нь садаа болдог.

Жишээлбэл: Харааны хөгжлийн бэрхшээлтэй охин эсвэл сонсголгүй учраас сурч чадахгүй гэдэгт багш итгэдэг. Гэвч охины харах сонсох чадвар нь асуудал биш. Харааны бэрхшээлтэй охин үнэрлэх хүрэлцэх мэдрэмжээ ашиглан суралцаж чадна. Тэр ч байтугай Брайль ном, аудио

хуурцагтай мэдээлэлтэй бол бүр ч ихийг сурах боломжтой. Харин сонсголгүй охин дохионы хэлээр харьцах, харааны аргыг хэрэглэх юм бол сурч чадна. Алхаж чадахгүй эмэгтэй өндөр албан тушаал хашиж гэр бүлээ тэжээх мөнгийг ч олж чадна. Хэрэв хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйг түүний гэр бүлийнхэн болон олон нийт түүнээс ичиж бусдаас нуух юм бол тэднийг сэтгэл зүйн хувьд гутамшигт байдалд оруулж жинхэнэ утгаар нь хөгжлийн бэрхшээлтэй болгодог.

Хөгжлийн бэрхшээлтэй олон эмэгтэйчүүд нуугдмал байдалтай амьдарч байна. Бид нийгэмд хамаардаггүй, учир нь хүмүүс биднийг эрүүл эмэгтэйчүүдээс доогуур үнэлдэг.



Олон нийт гэдэгт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг багтаан ойлгох нь хэвийн үзэгдэл. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй учраас тухайн эмэгтэйг ялгаварлан нийгмээс тусгаарлах нь байж боломгүй явдал. Тийм үзэгдэл хүмүүсийг зэрэмдэглэдэг!

Хөгжлийн бэрхшээл гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээлийн талаарх анагаах ухааны ойлголт

Олон эмч, эмнэлэгийн ажилтнууд хэн нэгний зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй байдлыг нь олж хардаг. Тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг “бие хүн”, эсвэл “эмэгтэй хүн” гэдэг талаас нь олж хардаггүй. Тэд “эрүүл мэнд нь сул” хүмүүсийг ямар нэг талаараа асуудалтай гэж үздэг бөгөөд тэдгээр хүмүүс эмчлүүлэх, сувилуулах, хамгаалуулах ёстой гэж үздэг.

Эмнэлэг болон бусад эрүүл мэндийн газруудын хүртээмжтэй байдал, сөрөг хандлага зэргээс эрүүл мэндийн үйлчилгээг хүн бүр хүртээмжтэй авах боломж хязгаарлагдмал байгаа нь эрүүл мэндийн тогтолцоонд ямар нэгэн асуудал байгааг харуулж байгаа бөгөөд түүнийг нь “эмчлэх сувилах” хэрэгтэй байна. Дээрх тохиолдолд энэ асуудал нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйн тухай асуудал биш боловч хөгжлийн бэрхшээлийн талаарх анагаах ухааны ойлголт нь тэдгээр эмэгтэйчүүдийг эрүүл энх элэг бүтэн амьдрах боломжгүй болгож байна.

Бид өөрийн хөгжлийн бэрхшээлдээ зохицон амьдарч чадна, харин та нар биднийг ялгаварлан гадуурхдаг байдлаа зогсоох ёстой.



Хөгжлийн бэрхшээл бол амьдралд байдаг л зүйл

Аль ч нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг. Мөн өвчин, осол гэмтлийн улмаас эмэгтэйчүүд хөгжлийн бэрхшээлтэй болдог. Гэхдээ засгийн газар, олон нийт хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй болгож байгаа нийгмийн шалтгаануудыг өөрчилж чадна. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн талаарх олон нийтийн хандлага өөрчлөгдөн ажлын байр бий болгосон цагт бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндийн байдал нь илүү сайжирна.

Энэтхэгийн Банглор хотын хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн үлгэр жишээ

Энэтхэгийн өмнөд хэсгийн Банглор хотод Шахина, Ноори, Дэвика, Чандрамма гэх хөгжлийн бэрхшээлтэй 4 эмэгтэй бусад эмэгтэйчүүддээ нөхөн сэргээх багаж хэрэгслүүдийг тэдний биед нь тааруулан хийж өгч байна. 1997 онд 8 хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй “Хөдөлгөөнт Энэтхэг” ТББ-аас зохион байгуулсан хиймэл эрхтэн хийх сургалтанд анх хамрагдаж хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн сэргээн засах засварын газрыг ажиллуулсан байна.



Хэдийгээр тухайн үед ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг газрууд байсан ч ажилчид нь эрэгтэйчүүд байдаг тул хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд тухайн газарт очиж үйлчлүүлэхээс татгалздаг байв. Тэд эрэгтэй хүнээр биеэсээ хэмжээ авахуулж, хиймэл эрхтэн хийлгүүлэхээс ичдэг байв. Энэ шалтгааны улмаас маш олон эмэгтэй тэдэнд эвтэйхэн, таарсан, хөдөлгөөнд нэмэр болох хиймэл эрхтэнг ашиглаж чаддаггүй байлаа. Одоо хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн сэргээн засах засварын газар шагай, тохой, өвдөгний олон төрлийн нөхөн сэргээх эрхтэнг хийдэг. Мөн суга таяг, тэргэнцэр, гутал, бүс хийх, дээр нь хиймэл эрхтэн хийдэг, бэхэлдэг болсон байна.

Сэргээн засах газрын эмэгтэйчүүд чадвараа дээшлүүлэн урам зориг нь нэмэгдсэнийхээ дараа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажилладаг бусад байгууллагууд, зарим эмнэлгүүд, Банглор хотын хувийн эмч нартай хамтран ажиллаж үйлчилгээ үзүүлж эхэлсэн. Эмэгтэйчүүд туслах материалуудаа авна, үйлчлүүлэгчдийнхээ бүртгэлийг хөтлөнө, чадвараа хөгжүүлэх эрэл хайгуул тогтмол хийнэ, бизнесээ удирдана гээд мундахгүй их ажилтай болсон.

Сэргээн засах газрын эмэгтэйчүүд бусад эмэгтэйчүүдийг зоригжуулан мэргэшүүлэх сургалтандаа хамруулж хиймэл эрхтэн засах чадвартай болгодог. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, ялангуяа гэр бүлийнхэндээ гадуурхагддаг эмэгтэйчүүдэд бүгд тэгш эрхтэй гэдгийг баталснаар зогсохгүй тэднийг амьдралтай нь залгуулсан юм.

Боломж ба бололцоо

Олон улс оронд эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн нөөц боломж бага байдаг. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын энэ ялгаатай байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд ч мөн адил.

Тэргэнцэр, хиймэл эрхтэн, дохионы хэл сурах анги, Брайл ном болон бусад эх үүсвэрүүд бүгд өндөр үнэтэй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд эдгээр нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад олдоц муу байдаг.

Боломж бололцоо нэмэгдсэнээр бид бусдад танигдаж, бидний хийснийг хүмүүс сонсож, бид өөрсдийн эрүүл мэндийг хянаж чаддаг болно.



Дээрх дэмжлэггүй орчин нь охид, эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших, аливааг өөрөө хийхэд маш хүнд байдаг.

Үүний дүнд эмэгтэйчүүд ажилд орох, амьдралаа авч явах, нийгмийн идэвхтэй хэсэг болох боломж мөн л бага болдог.

Бие махбодийн саад бэрхшээлүүд

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд банк, эмнэлэг зэрэг олон нийтийн газруудаар үйлчлүүлж бараг чаддаггүй. Учир нь ихэнх барилгад налуу шат, бариул, ачаа өргөгч, цахилгаан шат байдаггүй. Бие махбодийн саад бэрхшээл нь хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг эргэн тойрондоо чөлөөтэй хөдлөхөд хүндрэл учруулдаг. Налуу шатгүй учраас байшинд орж чадахгүй байгааг тэргэнцэртэй эмэгтэйд хиймэл хөл, суга таяг, эсвэл өргөж явах хүн хэрэгтэй гэдэг бодолдоо ихэнх хүмүүс, тэр ч бүү хэл эрүүл мэндийн ажилтнууд хүртэл өөрсдөө итгэдэг. Тэр эмэгтэй хөгжлийн бэрхшээлтэйдээ биш бие бялдрын саад нь түүнийг байшинд орохыг нь бүтэшгүй зүйл болгож байна. Хэрвээ байшин налуу шаттай байсан бол эмэгтэй дугуйгаа өөрөө эргүүлээд л байшинд орох бөгөөд тэнд ямар ч асуудал үүсэхгүй байх байсан.



Би хөгжлийн бэрхшээлтэй ээж. Надад бас хөгжлийн бэрхшээлтэй хүү байдаг. Бид зоогийн газарт очих, дэлгүүр хэсэх зэрэг олон нийтийн газруудад очих бүрт шатаар өгсөх хэрэг гарч, тэр үедээ байнга хэн нэгнээр өргүүлэх хэрэг гардаг. Тэр байдал маань олны анхаарлыг маш ихээр татдаг бөгөөд бид хүний оронцог юм гэсэн мэдрэмжийг төрүүлж, гутамшигтай санагддаг.

Хөгжлийн агентлагийн ажилтнууд төсөл хэрэгжүүлэхээр тосгонд иржээ. Тэд тосгоны бүх эмэгтэйчүүдтэй хамтран ажиллав. Тэнд амьдралаа авч яваа хөгжлийн бэрхшээлтэй нэгэн эмэгтэй байлаа. Тэд худаг гарган устай болгох төсөл хэрэгжүүлсэн ч худгаас хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй ус авах боломжгүй байв. Тэр эмэгтэй өөрөө усаа худгаас татаж авахыг хүсч байлаа. Гэтэл тэд энэ талаар ердөө ч бодоогүй юм.



—1985 онд Найробид болсон Дэлхийн эмэгтэйчүүдийн 3-р их хуралд оролцсон Зимбабын төлөөлөгчийн илтгэлээс.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд бид нийгмийн болоод бие махбодийн саад бэрхшээлийг арилгуулах эрхтэй.

Хөгжлийн бэрхшээлийн шалтгаанууд

Зарим эмэгтэйчүүд эхээс төрөхдөө ямар нэг хөгжлийн бэрхшээлтэй төрдөг. Харин зарим эмэгтэйчүүд цаг хугацааны явцад хөгжлийн бэрхшээлтэй болдог. Зарим эмэгтэйчүүд осол гэмтэл, өвчний улмаас олдмолоор хөгжлийн бэрхшээлтэй болдог.

Бүх хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх боломжгүй юм. Зарим хүүхэд эхийн хэвлийд байхдаа хэвийн бус бойжилттой болдог бөгөөд үүнийг хэн ч яагаад ийм болсон шалтгааныг мэддэггүй.

Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй олон хүүхэд эхийн амьдралын хэв маяг, хорт зуршлын хэрэглээ, амьдрах орчноос хамааралтай юм. Хэрвээ эх шим тэжээлтэй хоол идэж, ажлын орчинд химийн бодисын хорноос өөрийгөө хамгаалж, жирэмсний явц болон төрөх үедээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайн авч чадвал маш олон хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй төрөхөөс сэргийлэх боломжтой.

Ядуурал ба өлсгөлөн

Ядуурал бол хөгжлийн бэрхшээлтэй болох нэг томоохон шалтгаан. Ядуу хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй болох нь амархан байдаг. Учир нь тэд эрүүл ахуй ариун цэвэр таагүй орчинд ажиллаж, амьдардаг, боловсролын түвшин бага, цэвэр ус, хангалттай хоол хүнсээр дутагдаж өлөн зэлмэн амьдардаг. Энэ нь тэднийг хөгжлийн бэрхшээлтэй болгодог сүрьеэ, тархины саа өвчинд амархан өртүүлэх шалтгаан болдог. Эдгээр өвчнүүд нь нэгээс нөгөөд амархан халдварладаг тул дахин дахин өвчилдөг.



Ядуу гэр бүлд төрсөн олон хүүхэд төрөлхийн гажигтай эсвэл нярай үедээ нас бардаг. Энэ нь магадгүй эх жирэмсэн байхдаа хангалттай илчлэгтэй хоол хүнс хэрэглэж байгаагүйгээс шалтгаалсан байж болно. Эсвэл эх нь бага насандаа хоол тэжээлээр дутмаг орчинд өссөнтэй холбоотой байж болно. Хүүхэд наснаасаа эхлээд охид хөвгүүдийг бодвол хоол бага иддэг. Үүний дүнд өсөлт нь удааширч ясны хөгжил нь зохих ёсоороо явагддаггүй. Хэрвээ тухайн эмэгтэй эрүүл мэнддээ анхаарал тавихгүй бол хүүхэд төрүүлэх үед нь хүндрэл үүсгэх нэг шалтгаан болдог. Хэрэв нялх хүүхэд хангалттай хэмжээний хоол тэжээл идэхгүй бол хараагүй болох эсвэл суралцах ойлгох чадвар нь сулардаг.



Тагнай нь цоорхой, уруул нь сэтэрхийнэ охины ээж жирэмсэн байхдаа фоллийн хүчил, кальци (гүн ногоон навчит ногоонууд, шош, өндөг зэрэг хүнс) агуулсан хүнсийг хоолондоо хэрэглэж чаддаггүй байсан.

Дайн

Өнөөдөр дэлхий дээр болж байгаа дайнуудад цэргүүдээс илүүтэйгээр энгийн ард иргэд амь үрэгдэж байгаа бөгөөд тэдний дотор эмэгтэйчүүд их байна. Тэсрэлтээс болж хүмүүс сонсголгүй, хараагүй болж, хөл гараа алдах, мөн өөр бусад гэмтэл авч байна. Үүнээс гадна тухайн хүчирхийллийн улмаас тэдний сэтгэцийн эрүүл мэндийн байдалд ихээхэн нөлөө үзүүлж байна. Зөрчилдөөн, дайн хүмүүсийн гэр орон, сургууль, эрүүл мэндийн байгууллага, амьдрал залгуулдаг газруудыг нь сүйтгэж байгаагаас гадна тэднийг тахир дутуу, ядуу, өвчин эмгэгтэй болгож байна.

Өнөөдөр дэлхий дээр **дайнд хэрэглэдэг галт бөмбөг, тэсрэх бөмбөг, сум, химийн бодисууд** юу юунаас илүү хүмүүсийг хөгжлийн бэрхшээлтэй болгож байна. Эдгээр нь ихэнхдээ газар тариалан эрхэлж, ус, модоо цуглуулж гэр бүлээ авч яваа эмэгтэйчүүдийг гэмтээж бэртээдэг. Тэсрэлт, галт бөмбөгнөөс болж олон хүн хөл гараа бэртээж байгаагийн ихэнх нь хүүхдүүд байдаг бөгөөд хөл гараа тайруулсан 4 хүн тутмын 1 хиймэл эрхтэнтэй болдог. Учир нь хиймэл эрхтэн хэт үнэтэй эсвэл олдоцгүй байдаг.



Энэтхэгийн Мукти Сати хоёр хэмээх Жайпур хиймэл хөлний үйлдвэр хямд үнэтэй чанар сайтай бүтээгдэхүүн хийдэг. Энэ тухай илүү дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл 377-р хуудаснаас харна уу.

Галт бөмбөг аюулгүй болгох олон улсын гэрээ хийгдсэн нь олон хүний амийг аварч, гэмтэж бэртэхээс сэргийлж чадсан ч гэрээнд гарын үсэг зурахаас татгалзсан улс орнууд одоо ч гэсэн байсаар байна. Хэрвээ танай улс үүнд нэгдээгүй бол та бүхэн засгийн газартаа шахалт өгч гэрээнд гарын үсэг зурахад нь нөлөөлөх хэрэгтэй юм.

Цөмийн дэлбэрэлт

Их хэмжээний цацраг идэвхт бодис агаарт тархсаны дараа хүмүүс зовж эхэлдэг. 1979 онд АНУ-ын “Three Mile Island” цөмийн дулааны станцад гарсан осол, 1986 онд Украины Чернобилийн цахилгаан станцад болсон дэлбэрэлтээс хүмүүс зовсоор байна. Мөн 1945 онд АНУ Япон улсад цөмийн бөмбөг хаяхад мөн л хүмүүс зовж шаналсан. Дээрх хэргүүдээс үүдэлтэйгээр их хэмжээний сүйрэл болж цацраг идэвхт бодисонд хордсон хүмүүс үй олноороо амиа алдаж байсан.

Дэлбэрэлтийн дараа амьд үлдсэн хүмүүсийн ихэнх нь олон төрлийн хорт хавдар, ялангуяа бамбай булчирхайн эмгэг, эсвэл цусны хавдар тусч цаг бусаар эндэж байна. Жижиг суурин газруудад дээрх аваар осол гарч байсан бөгөөд үүнээс болоод суралцах чадвар муутай буюу Дауны хам шинжтэй хүүхдүүд олноор төрөх болсон.

Эрүүл мэндийн үйлчилгээг авах боломж хомс

Эрүүл мэндийн байдал сайн байх нь олон төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлж чадна. Хүнд хөдөлмөр эрхэлдэг эхээс болон төрөх үеийн хүндрэлээс тархины саажилттай хүүхэд төрөх магадлалтай байдаг. Жирэмсэн үеийн сургалтанд хамрагдаж эрсдлийг мэдэж улмаар түргэн тусламж шуурхай үйлчилгээ авснаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрүүлэхээс сэргийлж чадна. Эхийн дархлалын тогтолцоог сайжруулснаар олон төрлийн эмгэгээс урьдчилан сэргийлж чадна. Гэвч вакцин байхгүй, эсвэл ядуу учраас түүнийг тариулах боломжгүй, хол газар амьдарч байгаагаас үйлчилгээ холддог эсвэл вакцин хүн бүрт хүрэлцээгүй байх зэрэг олон шалтгаанаар хүмүүс вакцин тариулж чаддаггүй.

Өвчин

Жирэмсэн эхийн зарим өвчнүүдээс хүүхэд бие эрхтний болоод оюун ухааны хомсдолтой төрдөг. Хүүхдийг төрөлхийн эмгэгтэй болгодог өвчнүүдийн нэг бол улаанууд өвчин юм. Энэ өвчнөөр өвдсөн эхээс төрсөн шинэ нярай сонсголгүй байх нь нийтлэг тохиолддог. Улаанууд тусахаас хамгаалах вакцин байдаг ч тариулсан эмэгтэй нэг сар жирэмсэлж болохгүй. (Тэмбүү (163-р хуудас), херпес (165-р хуудас), ХДХВ (169-р хуудас) зэрэг өвчнүүд эхээс урагт халдварлаж болдог бөгөөд төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй болох шалтгаан болдог. Тиймээс хэвлийд байгаа хүүхдээ хамгаалахын тулд жирэмсэн эх эрүүл мэндийн үзлэгт орж бэлгийн замаар халдарлах өвчнөө эмчлүүлэх хэрэгтэй.

Менингит буюу тархины гадна хавдар, полиомиелит буюу тархины саа, улаанууд зэрэг **өвчин туссан нярай хүүхэд, бага насны хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол байдаг.** Шинэ төрсөн нярайн дархлалын тогтолцоог хамгаалах нь маш чухал (276-р хуудаснаа үзнэ үү). Уяман өвчний голомтонд амьдардаг хүүхдүүдийг аль болох эрт шинжилгээнд оруулах хэрэгтэй.



Жирэмсэн эх хүүхэд тээх эхний 3 сард улаан бурхан өвчнөөр өвчилбөл хүүхэд нь сонсголгүй төрөх магадлалтай.

Эм, тариа

Аливаа эм тариа, вакциныг зааврын дагуу зөв тунгаар хэрэглэхэд хүний эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс сэргийлэх ач холбогдолтой. Гэтэл шаардлагагүй тарилга хийх явдал тахал мэт дэлгэрч байна. Жил бүр шаардлагагүй тарилга олон сая хүнийг, ялангуяа хүүхдийг өвчлүүлж, хөгжлийн бэрхшээлтэй болгон, цаашилбал амь насанд нь хүрч байна.

Ариутгаагүй зүү тариураар тариа хийх нь халдварт өвчин тусах томоохон шалтгаан болдог бөгөөд ХДХВ/ДОХ, элэгний үрэвсэл (гепатит) зэрэг аюултай өвчний нянг дамжуулдаг. Ариутгаагүй тариур хэрэглэх нь халдвар авах нийтлэг зам бөгөөд халдвар нь даамжирч саажилт, нуруу нугасны гэмтэл, үхэлд хүргэдэг. Зарим тариануудыг тариулсаны дараа хүнд хэлбэрийн хариу урвал өгөх, хордлого болохоос гадна эхийн хэвлийд байгаа урагт нөлөөлж сонсголгүй болгох аюултай.



Шаардлагагүй үед тарилга бүү хийлгэ.

Зүү тариурыг нэгээс олон хүнд ердөө ч хэрэглэж болохгүй.

Жирэмсэн үед хэрэглэдэг зарим эм тарианууд урагт нөлөөлж хөгжлийн бэрхшээлтэй болгох шалтгаан болдог. Төрөлтийг хурдасгаж эхийг хүчээр дүлүүлэх окситоцин зэрэг эмийн тунг хэтрүүлбэл төрөлтийн явцад нярайг хүчилтөрөгчийн дутагдалд оруулдаг. Энэ нь нярайн тархийг гэмтээх гол шалтгаан болдог. Жирэмсэн үед архи, тамхийг хэрэглэх нь хүүхдийн хөгжлийг саатуулах аюултай.

Хүн бүр эмийн хэрэглээнээс гарч болох эрсдэл, үр ашгийг мэдэж байх хэрэгтэй. Эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнууд, эмийн санчид, ер нь бүх хүн эмийг, ялангуяа тарианы тунг хэтрүүлэн хэрэглэх, буруу хэрэглэх явдлыг зогсоох хэрэгтэй. Шаардлагагүй тарилга хийхийн хор хөнөөлийн талаар, **Эрүүл мэндийн ажилтнуудын мэдлэгт** хэсгээс үзнэ үү. 18, 19, 27-р бүлэг.

Ажлын байрны аюултай нөхцөл

Эмэгтэй хүн олон цагаар амралтгүй ажиллах нь аваарь осолд орсонтой ижил муу үр дагавартай. Химийн бодис хэрэглэдэг үйлдвэр, уурхай, газар тариалангийн салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүд хөгжлийн бэрхшээлтэй болох өндөр эрсдэлтэй юм.

Ажлын байрны дарамтанд байнга өртөж гэмтэл авсан эмэгтэйчүүдийн тоо өсч байгаа. Удирдлагууд эмэгтэйчүүдийг хурдан, шаргуу ажиллуулахын тулд зандран хүч хэрэглэх нь байдаг. Заримдаа цэрэг цагдаагийн байгууллагууд бүрэн эрхийнхээ дагуу эмэгтэйчүүдийг аюултай орчинд ажиллахыг нь болиулахаар цагдаагийн хамгаалалтанд авдаг.

Аваар осол

Маш олон хүүхэд, эмэгтэйчүүд ахуйн галд түлэгдэх, өндрөөс унах, зам тээврийн осолд орох, химийн хортой бодис уух, үнэрлэх зэргээр гэмтэж хөгжлийн бэрхшээлтэй болж байна. Мөн барилга, хөдөө аж ахуй, уурхай, жижиг бизнес эрхлэх зэрэг салбарт ажлын байртай холбоотой осол гарч хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй болдог.



Энэ эмэгтэй хүүхдээ тээж байхдаа аюултай химийн бодис ашигладаг хөдөө аж ахуйн салбарт ажилладаг байсан. Энэ нь урагт нөлөөлж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрөх шалтгаан болсон.

Пестицид болон хор

Будаг, хортон шавьж устгах болон хулганы хор зэрэгт агуулагддаг хорт бодисууд нь жирэмсэн эмэгтэйн ураг түүний ургийн өсөлт хөгжилд нөлөөлж хөгжлийн бэрхшээлтэй болгодог. Жирэмсэн үед утаат болон утаагүй тамхи татах, зажилдаг тамхи хэрэглэх, архи согтууруулах ундаа уух зэрэг нь урагт аюултай нөлөө үзүүлнэ.

Химийн бодис байнга хэрэглэдэг ажилтай хүмүүс тэр бодистой ажиллах аюулгүй ажиллагааны дүрмийг заалгаж байгаагүй, зарим нь бүр тухайн бодис ямар аюултайг ч мэддэггүй. Үйлдвэрийн осол аваар гарснаас хорт бодис агаар, ус, хөрсөнд шингэж хүн амын эрүүл мэндэд аймшигтай хор нөлөө учруулж хөгжлийн бэрхшээлтэй болгоход нөлөөлдөг.

Удамшдаг хөгжлийн бэрхшээл

Нурууны булчингийн сулрал, Дюшений өвчин буюу хуурамч хэт тэжээлийн булчин зовнил (булчин, мэдрэлийн тогтолцооны өвчин) зэрэг удамшлын өвчнүүд байдаг. Нэг болон түүнээс дээш удамшлын өвчтэй хүүхэд төрүүлсэн ээжээс мөн тийм хүүхэд төрөх нь элбэг. Цусан төрлийн холбоотой (ах дүү хоёр, үеэлүүд, эцэг эх болон хүүхэд) хүмүүсийн дундаас төрсөн хүүхдүүд удамшлын эмгэгтэй төрдөг. 40 болон түүнээс дээш настай эхээс Дауны синдромтой хүүхэд төрөх магадлал их байдаг. Гэсэн хэдий ч ихэнх хөгжлийн бэрхшээлүүд удамшлын бус гаралтай байдаг.

Ихэнх тохиолдолд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрүүлсэн эцэг эхээс авсан шинжилгээ судалгаанаас үзэхэд эцэг эхээс хамааралгүй байдаг. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд төрүүлсэнд нь тэднийг хэзээ ч буруутгаж болохгүй юм.



Хөгжлийн бэрхшээлийн талаарх мухар сүсэг болон буруу ойлголтууд

Тухайн ард түмний зан заншил, итгэл үнэмшилд хөгжлийн бэрхшээлтэй болдог талаар буруу ташаа ойлголтууд байдаг. Хэрвээ хэн нэгэн эмэгтэй хөгжлийн бэрхшээлтэй болбол түүний эцэг эх нь, эсвэл тэр эмэгтэй өөрөө урьд насандаа муу үйл хийсэн, өвөг дээдэст буян хийгээгүй, эцэг эх хоёрын хэн нэг нь гэр бүлээс гадуур хэн нэгэнтэй хормойн явдлаар холбоотой байсан гэх зэрэг шалтгаантай гэж зарим хүмүүс үздэг. Хүмүүс ихэвчлэн эхийг нь буруутгадаг. Гэвч хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй төрлөө гээд эхийг буруутгах ёсгүй. Тэгээд ч хэн нэгнийг буруутгалаа гээд ямар ч тус болохгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй байдлын талаарх өөр нэг ташаа ойлголт бол бусдаас “өөр” хэн нэгнийг гадуурхах, доог тохуу хийх, шүүмжлэх ёстой гэсэн итгэл үнэмшил байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүн муу ёр дагуулдаг, эсвэл азгүйтэл авчирдаг гэж зарим хүмүүс боддог. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд бусдад ашиглуулах, хүчирхийлэлд өртөх, гуйлга гуйх, эсвэл амьдралаа залгуулах гэж биеэ үнэлэх нь элбэг байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэлд их өртдөг. Учир нь зарим хүмүүс тэднийг ХДХВ/ДОХ тусддаггүй, тэр ч бүү хэл тэдэнтэй хавьтахад халдварт өвчин нь эдгэрдэг гэсэн ойлголттой байдаг.

Гэхдээ гашуун үнэн бол: Хөгжлийн бэрхшээлтэй нэг ч эмэгтэй бусдад ашиглагдах ёсгүй. Тийм төрсөн нь **ердөө ч** шийтгэл биш. Хөгжлийн бэрхшээлтэй болно гэдэг нь ямар нэгэн илбэ шид, дом жатга хийснээс болдог юм **биш**. Хөгжлийн бэрхшээлтэй байдал хэн нэгэнд **халдахгүй**, хүнээс хүнд **дамжихгүй**.

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд юу хийж чаддаг, бас юуг хийж чадахгүйг хүмүүс ойлгогддоггүй. Магадгүй хүмүүс тэднийг дараах зүйлсийг хийж чадна гэдгийг мэдэрдэггүй байх. Үүнд:

- Та насанд хүрсэн хүн, тиймээс шийдвэр гаргаж чадна.
- Танд боловсрол хэрэгтэй.
- танд эрүүл мэндийн тусламж хэрэгтэй.
- Та ХДХВ/ДОХ, хавдар гэх мэт олон төрлийн өвчин тусч болно.
- Танд бусдын харуусал, гомдол, өрөвдөл хэрэггүй харин сайхан боломж, хүндлэл хэрэгтэй.
- Та ажил хийж чадна. Та дээд зэрэглэлийн мэргэжилтэн болж чадна, мөн албан тушаал хашиж чадна.
- Та мөнгө хурааж, хөрөнгөтэй болж, түүнийгээ өсгөж, бас гэр бүлээ тэжээж чадна.
- Та бодож, мэдэрч, сэтгэл хөдлөл гаргаж чадна.
- Та бүжиглэж дасгал хийж чадна.
- Та өөрийгөө нийгэмд оруулж бусдыг манлайлж, шийдвэр гаргаж, хариуцлага хүлээж чадна.

Зарим жирэмсэн эмэгтэйчүүд манай дэлгүүрээс холуур явдаг. Учир нь тэд төрөх хүүхэд нь над шиг хэлгүй дүлий болно гэж боддог.



Би хүүхэд биш, миний өмнөөс бодох, үйлдэл хийхэд таны хэрэг байхгүй.

- та хэн нэгэнтэй дотно нөхөрлөж чадна. Та хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл эрүүл хэн нэгнийг хайрлаж, хайрлуулж чадна.
- танд сексийн дур хүсэл бий, бэлгийн идэвхтэй харьцаанд орж болно.
- та гэрлэж, үр хүүхэд төрүүлж чадна.
- та бэлгийн ажил хийх чадвартай ч хүсдэггүй байж болно.
- та оюуны хомсдолтой бол бусад эмэгтэйчүүдийг бодвол сексийн хэрэгцээ бага, эсвэл эсрэгээрээ их ч байж болно.
- та бусад эрүүл эмэгтэйчүүдийн адил олон хүүхэд төрүүлж чадна.
- та сайн ээж.
- та бие бялдрын хөгжил сул, суралцах чадвар муу байлаа гээд сэтгэцийн хувьд өвчтэй, тогтворгүй гэсэн үг биш.
- та хараагдсан хүүхэд биш, хараагдсан хүн биш, хүмүүс зугтахгаар тийм муу ёрын амьтан ч биш.



Өөрчлөхөөр ажиллах

Хэн нэгэн эмэгтэй хөгжлийн бэрхшээлтэй байх нь ганцхан түүнтэй хамааралтай асуудал биш. Түүний дотны хүмүүс болох гэр бүл, найз нөхөд, эргэн тойрныхон, нийгэм зэрэг олон хүнд хамааралтай асуудал юм. Эргэн тойрныхон нь түүнд тусалж, тэднийг үнэлэх юм бол хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд илүү эрүүл чийрэг болох боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг асран хамгаалж байсан хуучин аргаа өөрчлөх нь хүнд ажил. Гэхдээ боломжгүй зүйл биш.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол өвчтэй хүмүүс биш, харин ч бид маш эрүүл гэдгийг хэзээ нэгэн цагт хүмүүс ойлгоно гэж би мөрөөддөг. Эмэгтэйчүүд бид бүгдээрээ эрүүл байх хэрэгтэй.



Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн чадах зүйл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг эн тэргүүнд тавих, өөрийн эрхийг хамгаалуулах асуудлаар дуу хоолойгоо гаргах.

- Хаа нэгтээ хоригдож суухаас татгалзах. Зоригтой байж шинэ туршлага, мэдлэгийг дуртайгаар хүлээн авах.
- Бизнесийн ур чадварт суралцаж, өөрийгөө эдийн засгийн хувьд хүчирхэгжүүлэх.

Зах зээлд өөрийн гэсэн байр суурь эзлэх

Зимбабын тэргэнцэртэй иргэн Оппах Ндлову хүмүүсийн хүндлэл хүлээсэн нийгмийн хүндтэй гишүүн. Тэрээр төмс, хүнсний ногоо борлуулах төслийг санаачлан амжилттай эхлүүлсэн байна. Харин одоо тэр байнгын худалдан авагч нартай болсон. Бас Оппах байнгын орлоготой болсноор байшин худалдан авч чадсан байна.

- Нийгмийн бүхий л түвшинд оролцохыг шаардах.
- Бусад охид эмэгтэйчүүдэд үлгэр дууриал болох.
- Өөрийнхөө хөгжлийн бэрхшээлийн тухай ярилцах.
- Хөгжлийн бэрхшээлтэй бусад охид эмэгтэйчүүдэд хаана очиж хэнд хандахыг нь хэлж өгөх.
- Спортоор хичээллэх.

Өөрийнхөө түүхийг
бусадтай хуваалцах.



Олимпийн түвшний хөнгөн атлетик



Тархины саажилтай, эрхтэнээ тайруулсан, хөдлөх эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон улсын хөнгөн атлетикийн тэмцээн болох Параолимпод эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэж байгаа. Параолимп 4 жил тутам Олимпын наадмын дараа болдог. Энд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд итгэл найдвар, ур чадвараа уралдуулдаг, түүнийгээ олон хүнд харуулж, тэдний нүдийг нээж өгдөг сайхан арга хэмжээ юм.

Боулингийн тамирчны домог

Уганда улсын оны шилдэг тамирчинд нэр дэвшиж байсан хараагүй боулингийн тамирчин Констанс Сибанда хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн домог болсон хүн бөгөөд түүний тухай домог яриа “амь бөхтэй” яригдсаар байгаа билээ. Констанс дэлхийн аваргын тэмцээнээс хос алтан медаль хүртэж байсан. Тэрээр хараагүй хүмүүсийн боулингийн тэмцээнээс олон тооны медаль цуглуулсаныхаа дараа Өмнөд Африк, Шотланд, Их Британи зэрэг орнуудад тэмцээнд оролцож байсан юм. Констанс бол бүх охид эмэгтэйчүүдийг нууц авъяасаа нээх хүслийг бадраасан хүн билээ.

Та бүхэн нийгэмд юуг өөрчлөх шаардлагатай байгааг хамтын оролцоотой тогтоож бүх хүмүүсийн амьдралыг илүү сайхан болгох шийдвэр гаргаж чадна. Жишээлбэл, та дараах зүйлсийг хийж чадна:

- Уншиж бичиж чаддаггүй эмэгтэйчүүдэд зориулсан анхан шатны хичээлийг эхлүүлэх;
- Хамтдаа гар урлал хийж түүнийгээ борлуулах жижиг бизнес эхлүүлэх;
- Нийгмийн үйлчилгээний талаарх мэдээллийг бие биетэйгээ хуваалцаж илүү хүртээмжтэй болгохын тулд хамтдаа ажиллах;
- Хөрөнгө оруулалт олохыг оролдох, бага хүүтэй зээл авах, хандив цуглуулах зэргээр хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлж орлого олох төсөл хэрэгжүүлэх, үгүй бол олон нийтийг илүү идэвхитэй болгох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх мөн бие даан амьдрах талаар шинэ арга замыг дэмжих;
- засгийн газар болон орон нутгийн төлөөлөгч нартай хамт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд илүү сайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмчилгээ үзүүлэх талаар хамтран ажиллах;



Та нийгмийн бүлэгт тусалж чадна:

- Та болон бусад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тулгардаг эрүүл мэндийн асуудлын талаар олон нийт алийг нь өөрчилж чадах шийдлийг;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэнд, боловсрол, тээврийн үйлчилгээг илүү сайн хүргэж, хүн бүрийн амьдралыг дээшлүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ авах. Барилга байгууламжуудыг хүртээмжтэй болгохыг шаардах;
- Жижиг бүлгэм байгуулах. Хэн нэгний дуу хоолойноос байгууллагын дуу хоолой илүү хүчтэй байдаг. Өөрт байгаа санаа тус бүрийг гүйцэлдүүлэхийн тулд ямар алхам хийх тухай төлөвлөгөө гарга;
- Та бүхнийг ялгаварлан гадуурхаж байгаа бодлого, хуулийн эсрэг өөрсдийнхөө дуу хоолойг өргө;



Нэгэн цагт Уганда улсад дүлий хүмүүс машин жолоодох эрхгүй байсан. Гэхдээ бид үүнийг эсэргүүцсэнээр жолоо барих эрхтэй болж машин худалдан авч чадахаар болсон.

Хүмүүсийг боловсролыг нэмэгдүүлэх нь

Банглог хотын тэргэнцэртэй эмэгтэй Дороти, Энэтхэгийн нийслэлд барилга хот тохижилт хариуцсан сайдын ажлын өрөө байрладаг барилга нь налуу шатгүй байгааг олж мэджээ. Түүгээр зогсохгүй, барилгын орох хаалга түүний хувьд хэт нарийн байсан байна. Тэрээр хамгаалалтын ажилтнуудад үүнийгээ хэлээд түүнийг шаардлагыг хүлээн авахыг хүссэн байна. Хэсэг хугацааны дараа Дороти хүмүүст зуу зуун имэйл явуулж юу болсон талаар асуусаар байжээ. Энэ байдал нь засгийн газарт ихээхэн дарамт учруулсан тул өөрчлөхөөс аргагүй байдалд хүрчээ.

Өөр нэгэн өдөр Дороти крикетийн тоглолт үзэхээр ирэхэд тэнд байсан цагдаа түүнээс: “Та яагаад энд ирэхийг хүссэн юм бэ, крикетийн тоглолтыг амьдаар нь үзэхийг хүссэн юмуу? Гэртээ суугаад зурагтаар үзсэн нь танд илүү тухтай юм биш үү” гэж асуухад нь Дороти: “би бусад хүмүүс шиг тоглолтыг амьдаар нь үзэхийг маш их хүсч байна” хэмээн хариулжээ.

Гэр бүлийнхэн юу хийж чадах вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг асран халамжилж байгаа гэр бүлийнхэн, найз нөхөд, бусад хүмүүс тэднийг буруугаар, бусдаар өөр мэтээр хардаг.

Хөгжлийн бэрхшээлтэй охидыг тэнэг, бусдаас хараат, өөртөө болон бусдад тусалж чадахгүй, ямар ч чадваргүй хүн болгон харах нь маш түгээмэл байдаг.

Заримдаа гэр бүлийнхэн нь тэднийг гутамшигтай хүнд ачаа мэтээр харж бусдаас нуух, үл сонсох, өөрөө шийдвэр гаргах эрхийг нь үгүйсгэдэг. Хэрэв ийм байдал гэр бүлд болон нийгэмд байсаар байвал гол асуудал хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд биш түүнийг хүрээлж байгаа хүмүүст байна гэсэн үг.



Итгэл найдвараа хөгжүүлэх

Кристин 13 настай байхдаа өвчний улмаас хөлөө тайруулжээ. Эхэндээ охин энэ явдал түүний мөрөөдлийг үгүй хийсэн гэж боддог байлаа. Гэвч түүний эцэг эх нь Кристинийг сайн асарч ухааруулсанаар нэг их удалгүй түүний итгэл найдвар нь сэргэжээ. Эхэндээ эцэг эх нь түүнийг маш ихээр хамгаалдаг байсанд охин бусад ах дүү нарт ханддаг шигээ өөрт нь тийнхүү байхыг шаарддаг байж. Кристин коллежээ төгсөж онц сурлагатаны шагналыг хүртэл авч чадсан байна. Кристиний энэ өөрчлөлт түүний гэр бүл, эргэн тойрныхонд түүний алдсан нэг хөл нь мөрөөдлөө биелүүлэхэд нь ямар ч саад болохгүй юм байна гэдгийг ойлгуулж чаджээ.

Энэ хандлагыг өөрчлөх ганцхан зүйл бол нийгмийн ухамсар. Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдэд хоол хүнс, боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, бие махбодийн болон нийгмийн үйл ажиллагаанд оролцох боломж зайлшгүй хэрэгтэй. “Сэтгэцийн эрүүл мэнд”, “асран хамгаалагч нарт өгөх тусламж” бүлгүүдээс илүү дэлгэрэнгүй харна уу.



Та маш олон чадвараа хөгжүүлж чадна

Лаос улсын иргэн Хонг Ха 2 настай байхдаа полиомелит өвчнөөр өвджээ. Гэр бүлийнхэнийхээ дэмжлэгтэйгээр тэрээр Францад их сургуульд суралцан төгсөж чадсан юм. Хонг Ха ажил хайгаад олж чадалгүй оёдол хийхийг сурч, гэртээ оёдлын газар байгуулав. Оёдол хийж байх зуураа тэрээр Англи хэл сурсан байна. Тэрээр өөрийн нэг найзын хамтаар гэртээ жижигхэн Англи хэлний сургалтын төв нээн ажиллуулжээ. Мөн тэрээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөтөлбөрийн зохицуулагчаар ажилладаг юм.

Аль болох эртхэн тусламж үзүүлэх

Хүүхэд амьдралынхаа эхний жилүүдэд бие бялдар, сэтгэц, харилцааны болон нийгмийн чадваруудад амьдралынхаа бусад үеүдтэй харьцуулахад илүү ихээр, илүү хурдан суралцдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн аливаа зүйлийг сурч эхлэнгүүт гэр бүлийнхэн нь түүнд онцгой анхаарал хандуулж туслах хэрэгтэй. Шинээр сурч байгаа чадвар бүр нь хүүхдийн өөрийнх нь байгалиас заяасан чадварыг дээшлүүлэхэд нь тус болдог тул маш чухал байдаг. Шинэ чадвар бүхэн хүүхдийг өөр бусад зүйлсийг сурах, хүндхэн чадваруудыг эзэмшихэд илүү давуу талтай байдаг. Тиймээс хүүхэд ямар нэгэн чадварыг сурахгүй бол түүнтэй хамааралтай өөр бусад чадваруудыг мөн адил сурахгүй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлэх бүлгэм байгуулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эмэгтэй ихэвчлэн залуу насандаа нөхөртөө хаягдан хүүхдээ ганцаараа өсгөх шаардлагатай болдог. Эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлэх бүлгэм түүнд тусалж чадна. Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн эмэгтэйчүүд хөгжлийн бэрхшээлтэй охидод өсөж том болоход нь тулгардаг олон зүйлсийн талаар зөвлөгөө өгч чадна. Энэ нь охидын ээж нарт охиддоо дэмжлэг үзүүлэхэд нь маш их тус болдог.

Үүнээс гадна та нар өсвөр насны хөгжлийн бэрхшээлтэй охид бие биедээ туслах охидын бүлгэм ч байгуулж болно.

Олон нийт юу хийж чадах вэ?

Нийгмийн сайн дурын бүлгүүд нь засгийн газар, эрүүл мэндийн ажилтнууд, багш нар, олон нийтэд түшиглэсэн нөхөн сэргээх төвийн ажилтнууд, нийгмийн удирдагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг асуудлыг ойлгоход тусалж



Эрүүл мэндийн ажилтнууд, багш нар, нийгмийг тэргүүлэгчид, гэр бүлийнхэн, хөршүүд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ханддаг хандлагаа өөрчлөх юм бол бид өөрсдийн ажлаа хийж чадна. Бас хүчирхэг холбоог бий болгон өөрсдийн нийгмийг илүү баялаг хүчирхэг болгоно.

чадна. Мөн тэд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд боловсрол, эрүүл мэнд, тээврийн үйлчилгээг жирийн эмэгтэйчүүдийн нэгэн адил авах эрхтэй гэдгийг гудамжны тоглолт хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг аргаар олон нийтэд ойлгуулах ажлыг хийж чадна. Олон нийт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд үйлчилгээний талаар мэдээлэл өгөх, тэдний хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж чадна.

Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдийг гэр бүлийнхэн нь хүлээн зөвшөөрч, тэднийг хайрлах юм бол тэд өөртөө итгэлтэй болж авъяас чадвараа бүрэн дайчлан амьдрах итгэл үнэмшилтэй болдог. Мөн боловсролтой, ажилтай, эрүүл мэндийн үйлчилгээг авч чадах нь тэднийг маш ихээр идэвхжүүлдэг. Сургууль, банк, шашны газар, эмнэлэг, сувилалын газар зэрэг олон нийтийн бүх газрууд хүн бүрт хүртээмжтэй болох ёстой.

Боловсрол

Хөгжлийн бэрхшээлтэй охидод боловсрол маш чухал юм. Ялангуяа, харааны, сонсголын бэрхшээлтэй хөгжлийн бэрхшээлтэй охидод дохионы хэл, брайл хэл ашиглан хичээл явуулах, тэдэнд зориулсан аудио хуурцаг маш чухал байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй охидын сургуульд сурах боломж хөгжлийн бэрхшээлтэй хөвгүүдийнхээс бага байдаг.



Ядуу буурай орны олон охид боловсрол эзэмших нөхцөл бүрдээгүй учраас сургуульд явж чаддаггүй бөгөөд тэдний ихэнх нь насанд хүрсэн хойноо гуйлга гуйн амь зуусаар насыг бардаг.

Уншиж бичиж чаддаг байх нь надад нэр хүндтэй амьдрах, хуримтлал үүсгэх боломжийг олгодог.



Нийгэм бүхлээрээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн суралцах эрхийг хангахын төлөө ажиллавал маш том өөрчлөлтийг хийж чадна.

Олон нийтэд түшиглэсэн бүлэглэлүүд бусад хүүхдүүдэд хөгжлийн бэрхшээлтэй охидыг хүндэтгэх, тэднийг хүлээн зөвшөөрөх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тулгардаг хүндрэлтэй асуудлуудыг хэлэлцэн бусдыг уриалж чадна. Тэд бага насандаа боловсрол эзэмших, засгийн газрын тэтгэлэг авах, өөр аргаар тусламж үзүүлэх зэрэг боломжийг тогтоож чадна. Хөгжлийн

бэрхшээлтэй охид боловсрол эзэмшин тухайн нийгэмдээ үр дүнгээ өгч чадна.

Хүн бүрт хүртээмжтэй нийгэм бий болгох

Дэлхий даяар хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд эмнэлэг, сургууль, зах, хотын гудамж, автобус, түүнчлэн нийгмийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгоход туслах ажлыг зохион байгуулж байна.

Олон нийт зам барилгыг баригдаж дууссаны дараа өөрчлөх бус барихаасаа өмнө хүн бүрт хүртээмжтэй байхыг нь бодолцож хийх хэрэгтэй. Ийм аргаар олон нийтийн газруудыг бүгдийг нь хүртээмжтэй болгож нас хүйс, чадвар, нөхцөл байдлаараа нийгмээс тусгаарлагдаж байгаа олон хүнд хүртээмжтэй болно. Түүгээр ч зогсохгүй энэ нь хөгшин залуу, чадалтай чадалгүй, сайн, эсвэл хүнд нөхцөлд байгаа олон хүний хэрэгцээг хангаж чадна (38 - 40-р хуудаснаа харна уу).

Би үргэлж өөрийгөө бусад нэмэргүй амьтан гэдгийг мэддэгдэг. Гэрээсээ гарах тоолондоо би хэн нэгний тусламжийг авдаг. Хэрэв миний амьдардаг байшинд налуу шат байдагсан бол, олон нийтийн газруудад налуу шат байдагсан бол би өөрөө өөрийгөө аваад явж чадах байсан. Би байнга будсыг хүлээж суухын оронд хүссэн үедээ гадагшаа гарах байсан.



Гэхдээ хүртээмжтэй байдал гэдэг налуу шат гэхээс илүүтэй бие махбодын хүртээмжтэй байдлыг хэлж байгаа юм. Мөн хүртээмжтэй байдал гэж юу болж байгаа талаар хүмүүс бүгд хоорондоо харилцах, ойлголцох үйл явц юм. Үүнийг ойлгосон цагт хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй илүү ихийг хийж чадах бөгөөд хүмүүс ч гэсэн хөгжлийн бэрхшээл гэдгийг амьдралд байдаг л зүйл гэдгийг ойлгоно. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд нийгэмд үнэ цэнэтэй болохын хирээр олон нийт хөгжлийн бэрхшээлийн талаарх асуудлыг өөрөөр бодож эхлэнэ.

Засгийн газар хүн бүр ашигладаг нийтийн тээвэр, барилга, олон нийтийн хөтөлбөр, нийтийн эзэмшлийн газруудыг хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд болон бусад бүх хүмүүст ашиглахад хялбар, төвөггүй байхаар шийдвэрлэх ёстой. Зарим улсад ингэж хамтран ажиллахаас татгалзсан хэнийг ч бай торгодог хуультай юм байна.



Засгийн газар өөрчлөлт хийе

Лаосын Хөгжлийн Бэрхшээлтэй Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Төв нь “Саадгүй орчин” семинарт хамрагдсанаа дараа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саадгүй орчин үүсгэсэн тухай бичлэгтэй хуурцагнуудыг гаргасан.

Тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоонд хүртээмжтэй орчин хэрхэн нөлөөлж байгаа талаар төр засгийн байгууллагуудтай ярилцаж эхэлсэн.

Тэдний санааг

- ☐ Ерөнхий сайд
- ☐ олон нийтийн харилцаа
- ☐ тээврийн
- ☐ гадаад харилцааны
- ☐ шуудан холбооны
- ☐ нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамдууд хүлээн авч баталсан. Тэд улсынхаа нийслэл Вьентьян хотын 47 албан газрын барилгад налуу шат хийх төсвийг гаргуулан үүнийгээ хэрэгжүүлсэн байна.



Боломжийг нээх

Мексик улсын иргэн Алися Контерас хүүхэд байхдаа полимелит өвчнөөр өвджээ. Нэгэн шилдэг эмч түүний эцэг эхэд охиндоо сэтгэл санааны дэмжлэг өгч бие даалгах нь маш ач тустай болохыг зөвлөсөн байна. Эцэг эх нь охиноо жирийн дунд сургуульд явуулахаар холбогдох хүмүүстэй нь тохиролцжээ. Охин тус сургуульд суралцсан хамгийн анхны хөгжлийн бэрхшээлтэй сурагч байсан бөгөөд түүний энэ амжилт хөгжлийн бэрхшээлтэй олон хүүхдэд тус сургуулийн үүдийг нээж өгсөн байна. Алися их сургуульд элсэн орлоо. Гэтэл түүний хичээлийн танхим гурван давхарт байрладаг бөгөөд суга таягтай түүнд дээшээ өгсөх маш хэцүү байдаг байлаа. Алися сургуулийн захиралтай уулзан гурван давхарт байрлах хичээлийн танхимыг нэгдүгээр давхарт нүүлгэж өгөхийг хүсчээ. Захирал шуудхан зөвшөөрсөн байна. Учир нь “Боломжтой өөр өрөө байгаа,” гэж Алисяд хэлсэн байна. “Харин захирал хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд дээд давхрын танхимуудад хичээллэх нь хичнээн хэцүү байх бол гэдгийг хэн нэгэн түүнээс асуугаагүй бол хэзээ ч бодож байгаагүй гэдгээ хэлжээ”. Өөр нэгэн удаа Алися өөрчлөлт хийх ширүүн тэмцэлд оролцох хэрэг гарчээ. Алися “Хүртээмжтэй орчин” нэртэй нийгэмлэгийн гишүүн болжээ. Тэр бүлэглэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүстэй адил эрхтэй учраас нийгмийг тэдэнд илүү хүртээмжтэй болгохыг шаардан ажилладаг байлаа.

Жишээлбэл, тэд хотын тээврийн газартай уулзан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хотоор явахад ямар хүнд байдгийг хэлжээ. Үүний дүнд тэдэнд зориулагдсан автобуснууд хотоор явдаг болов. Хүртээмжтэй орчин нийгэмлэгийн үйл ажиллагаа одоо ч идэвхтэй байгаа билээ.



1993 оноос тус нийгэмлэг төрийн болон төрийн бус байгууллагуудыг идэвхжүүлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг дээшлүүлэхээр хамтран ажиллаж байна. Гэсэн ч тэдний өмнө хийх шаардлагатай маш олон ажлууд байсаар л байна!

Өөрчлөлтийн бодлого боловсруулах нь хялбар ажил биш. Цаг хугацаа шаардсан хүнд ажил юм. Үүнд олон жилийн хөдөлмөр олон хүний дэмжлэг шаардагдана. Таны өөрчлөхийг хүсч байгаа байдалд нөлөөлөхүйц бодлогыг гаргахад, мөн ажиллаж байгаа хүмүүст нөлөөлөхөд зардал гарна гэдгийг тооцоолох ёстой. Таныг өөрчлөлт хийхээр ажиллах үед урмыг тань хугалах зүйлс олон тохиолдоно. Харин та урам хугарч сэтгэлээр унасан үедээ өөрийн орныхоо, эсвэл өөр орны хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдээс зөвлөгөө аваарай. Та хүртээмжтэй нийгмийг бий болгож чадна.

Энд та бүхэнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийн амьдарч буй хотдоо маш том өөрчлөлтийг хийж чадсан түүхийн талаар өгүүлье.

Хүртээмжтэй хот бий болгох

ОХУ-ын Екатеринбург хотын Нийгмийн Хөдөлгөөний Эрх Чөлөө байгууллага хотын захиргаатайгаа хамтран хотоо илүү хүртээмжтэй болгохоор ажилладаг. ОХУ-ын хуулинд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийтийн тээвэр, олон нийтийн газруудад зорчих эрхтэй гэж заасан ч өнөөг хүртэл маш олон газрууд хүртээмжтэй орчин бүрдүүлээгүй байсаар байна. Екатеринбург хотын захиргаа барилга байгууламжуудыг хүртээмжтэй болгохын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөтөлбөрийг боловсруулсан.

Гэвч засгийн газар тэдэнд туслахаар эрмэлзэн олон өөрчлөлтүүдийг хийсээр байгаа ч хийсэн өөрчлөлт нь тэргэнцэртэй иргэд, суга таяг хэрэглэдэг хүмүүст бэрхшээлтэй хэвээр байгаа нь мэдэгдсэн байна. Үүнээс үүдээд Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусалцаагүйгээр дангаар ажиллаж чадахгүй юм байна гэдгээ мэдэрчээ.

Энэхүү хэрэгцээнд үндэслэн Нийгмийн Хөдөлгөөний Эрх Чөлөө байгуулагдсан. Тэд хотынхоо хүртээмжтэй болгох шаардлагатай газруудын жагсаалтыг гаргахаас ажлаа эхэлсэн байна. Тэд хотын удирдлагуудтай уулзан жагсаалтаа үзүүлэхэд хотын захиргаа тэдэнтэй уулзан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зөвлөгөө тэдэнд хэрэгтэй байсныг ойлгосон байна. Нийгмийн Хөдөлгөөний Эрх Чөлөөнийхөн тэдний гишүүд, хотын комисс хамтран хүртээмжтэй орчныг бий болгох асуудлыг хариуцан ажиллахаар болсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс комиссын гаргасан ямар ч шийдвэрийг батлах ёстой.

Нийгмийн Хөдөлгөөний Эрх Чөлөөнийхөн барилга байгууламжуудыг хүртээмжтэй болгохын тулд архитекторуудад зориулсан удирдамж гаргасан. Тэд засвар хийхийг хүссэн барилгынхаа зургийг авч ямар өөрчлөлт хийхийг хүсч байгаагаа тодорхой зурж өгөх боломжтой болсон юм.



Одоо хуучин барилгуудууд бага багаар өөрчлөгдсөөр байна. Мөн шинэ удирдамж нь хот даяар ашиглагдаж байгаа. Нийгмийн Хөдөлгөөний Эрх Чөлөөнийхний хийсэн ажлын үр дүнд шинээр баригдаж байгаа албан газрууд, мөн орон сууцны барилгууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болсон. Тэргэнцэртэй хүмүүст зориулсан хажуугийн замуудыг нам дор байрлуулан хийсэн. Хотын шинэ их дэлгүүрээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үйлчлүүлэх таатай орчин бүрдсэн. Нийгмийн Хөдөлгөөний Эрх Чөлөөнийхөн хотын хэд хэдэн дунд сургуулийг, кино театрыг боломжийнхоо хирээр өөрчилсөн гэх зэрэг олон амжилт гарчээ.

—Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ертөнц

Авсан арга хэмжээ

- Нийгмийн үйл ажиллагаа зохион байгуулах: Хөгжлийн бэрхшээлтэй охид гэрээсээ гарч үе тэнгийн охид болон хөгжлийн бэрхшээлтэй өөр хүмүүстэй уулзахад нь туслах
- Мэдээллээ хуваалцах: Шинээр олж мэдсэн зүйл, эсвэл санаачилсан ажлынхаа талаар
- Эмэгтэйчүүдэд туслах: Гэр орон, олон нийтийн газар, ажлын байрандаа дарамтанд өртөж байгаа
- Сургалтанд хамруулах: Амьдрах ухаан, манлайлал

Арга хэмжээ өгөхөд нийгэмдээ тусалж байгаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд зориулсан зарим нэг санааг хэлье.



Уганда улсад нөөц боломжоор хангах замаар хийгдсэн өөрчлөлт



Угандагийн Хөгжлийн Бэрхшээлтэй Эмэгтэйчүүдийн холбоо хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг бизнес эрхэлж эхлэхэд нь зээл олгох, боловсрол эзэмшүүлэх, явуулын эмнэлгийн тусламж үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн талаарх иргэдийн ухамсарыг дээшлүүлэх жүжиг тавих зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Тэд хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн төлөө, тэдний сайн сайхан амьдралын төлөө, хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдүүдэд илүү сайн боловсрол эзэмшүүлэхэд нөлөөлөх, бие даан амьдрах чадварт сургах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээллийг хуваалцах зэргээр “ядуурал, харанхуй бүдүүлэг байдал, нийгмийн ялгаа, өвчинтэй тэмцэж байна”.

Эл Сальвадор улсын эмэгтэйчүүдийн хийсэн өөрчлөлт

Эл Сальвадор улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн байгууллага болох ACOGIPRI 1987 оноос хойш эмэгтэйчүүдийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд тэд өөр өөр намтар түүхтэй эмэгтэйчүүдийг цуглуулан бэлгийн амьдрал болон бусад өвчний талаар хэлэлцүүлэг зохион байгуулдаг. Үүнээс гадна:

- Бичиг үсэг таниулах болон манлайллын сургалтанд хамруулах
- Хөгжлийн бэрхшээлийн төрлөөс үл хамааран охид эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн болон бусад төрлийн үйлчилгээг үзүүлэх.
- Ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх зэрэг ажлуудыг хийдэг байна.



Бүх хүн оролцож хүчирхэг нийгмийг бий болгоно



Дэлхий дээрх хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд мухар сүсэг, харанхуй бүдүүлэг байдал, ялгаварлан гадуурхалт зэрэг саад бэрхшээлийг үл тоон өөртөө итгэлтэй амьдрах чадвараа хөгжүүлэх хэрэгтэй.

Шат шатны шийдвэр гаргагчид хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн зөвхөн хөгжлийн бэрхшээлийн талаар бус бүхий л өгүүлж буй асуудлуудад анхаарал хандуулж сонсож байх хэрэгтэй.

Бүх асуултандаа хариулт авдаг хүн гэж байдаггүй. Хүний эрх, ажилтаны эрх, эмэгтэйчүүдийн нэр хүндийн төлөө тэмцдэг эрэгтэй, эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй бэрхшээлгүй бүх хүн хамтдаа дэлхийн өнцөг булан бүрт байгаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг эрүүл саруул, бие даасан, үр хүүхэдтэй болон амьдрахад нь туслах үйлсэд нэгдэх ёстой.

Бид амьдралаас сурсан бүхнээ бусадтайгаа хуваалцсанаар бид бүгдэд зориулагдсан ертөнцийг байгуулж чадна.

Бүх хүн нь эрүүл саруул, бүгдэд хүртээмжтэй нийгмийг бий болгоход ямар өөрчлөлт тус болох талаар бүгдээрээ ярилцъя.



